



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 452

Улаанбаатар хот

“Ган-Яармаг” ХЗХ-нд тусгай зөвшөөрөл олгох, төсөл хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ эрхлэхийг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 22.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10.1.1, 15.3.4, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13.1, 15.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны зохицуулалтын журам”-ын 4.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 82 дугаар тогтоолын 1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Ган-Яармаг” ХЗХ-нд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар олгосугай.
2. Тус ХЗХ-нд төсөл, хөтөлбөрийг дамжуулан хэрэгжүүлэх үйлчилгээ эрхлэхийг зөвшөөрсүгэй.
3. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах, тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд зөвшөөрлийн талаарх тэмдэглэгээг 2014 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн дотор хийлгэхийг “Ган-Яармаг” ХЗХ /П.Наранцэцэг/-нд үүрэг болгосугай.
4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

030454